



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 301

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Завхан аймаг дахь Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглах, сэргээн засварлах боломжгүй болсон нь Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2012 оны 07/07/027/363, 2016 оны 07/06/021/88, 2019 оны 07/07/027/47 дугаар актаар тус тус тогтоогдсон, 5 нэрийн нийт 138,186,800.00 /нэг зуун найман сая нэг зуун наян зургаан мянга найман зуун/ төгрөгийн балансын үнэ, 6,968,419.68 /зургаан сая есөн зуун жаран найман мянга дөрвөн зуун арван есөн төгрөг жаран найман мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, Завхан аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор Ц.Дэнсмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг байгууллагын мэдэлд хэвээр үлдээж төрийн захиргааны байгууллагын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4. Авсан арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ 0047

Төрийн өчмийн бодлого зохицуулалтын
газрын 2020 оны 05 дугаар сарын 19. ны
өдрийн 30/ дугаарт тооолын хавсралт

**ЗАВХАН АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН УНДСЭН ХӨВӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
АКТЛАЖ ДАНСНААС ХАСАХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдээп (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Конторын барилга	1969.01.01		1	130,690,180.00	2,178,169.68	128,512,010.30
2	Автограж	2003.01.01	Завхан аймаг	1	4,790,250.00	4,790,250.00	0.00
3	Зулэгжүүлсэн тапбай	2018.12.31	Улиастай сум Жинст баг	1	1,790,390.00		1,790,390.00
4	Явган хүний зам	2018.12.31		1	403,780.00		403,780.00
5	Мод	2018.12.31		20	25,610.00		25,610.00
	Нийт дүн				138,186,800.00	6,968,419.68	130,731,790.30
					/зургаан сая есөн /нэг зүүн гучин найман сая нэг зүүн жаран найман зүүн жаран найман найман зүүн/ мөнгө/	/зургаан сая есөн зүүн жаран найман мянга дөрвөн зүүн арван есөн төгрөг жаран мянга найман зүүн/ мөнгө/	/нэг зүүн гучин сая долоон зүүн гучин нэгэн мянга долоон зүүн ерэн төгрөг гучин мөнгө/